

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/149/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2025 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: У.Ербол
	Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Аймгийн ИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

УЛААНХУС СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.БОТАКӨЗ ТАНАА

2025.09.03 № 18
танай _____-ны № _____-Т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй

Аудитын гол асуудал

1.Бараа материалын мал амьтад дансанд 9,900.0 мянган төгрөгийн үнэтэй 62 толгой бог мал бүртгэлтэй байгаа боловч бодитоор байхгүй байгааг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй, санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнасан.

2.Тээвэр шатахуун болон бараа үйлчилгээний бусад зардлаас 47,170,0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан боловч жолоочийн замын тооцооны хуудас хөтлөөгүй, шатахууны зарцуулалтыг гарын үсэг зуруулж баримтжуулаагүй, шатахууны төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

3.Батлагдсан орон тооны хязгаараас 7 орон тоог илүү ажиллуулж төсвөөс 43,232.6 мянган төгрөгийн зардал гаргасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дугаар зүйлийн 16.5-ийн 16.5.3, 16.5.9 дахь заалт, оршин байх, иж бүрэн байх, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23,334,601.00</u>	<u>31,298,066.15</u>
33	АВЛАГА	1,291,601.00	13,977,566.15
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,291,601.00	13,977,566.15
35	БАРАА МАТЕРИАЛ	22,043,000.00	17,320,500.00
354	Хангамжийн материал	12,143,000.00	7,420,500.00
35420	Аж ахуйн материал	12,143,000.00	7,420,500.00
35600	Мал амьтад	9,900,000.00	9,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,686,623,255.91</u>	<u>9,776,889,897.65</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,686,623,255.91	9,776,889,897.65
392	Биет хөрөнгө	9,458,364,620.07	9,548,599,154.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,052,359,673.51	3,172,359,673.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	(401,663,741.30)	(475,618,939.82)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88,798,334.00	121,140,834.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(39,601,350.62)	(55,000,342.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,661,515.00	126,509,065.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(41,416,931.66)	(55,666,357.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,466,371.00	28,624,371.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,015,104.36)	(5,859,552.18)
39209	Зам, гүүрийн байгууламж	6,847,437,384.00	6,847,437,384.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(282,893,473.98)	(525,681,981.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	168,700,000.00	418,300,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(25,468,055.52)	(47,945,000.13)
393	Биет бус хөрөнгө	228,258,635.84	228,290,742.86
39301	Програм хангамж	11,759,639.00	12,529,639.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,005,003.16)	(1,742,896.14)
39303	Бусад биет бус хөрөнгө	217,504,000.00	217,504,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>9,709,957,856.91</u>	<u>9,808,187,963.80</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>9,709,957,856.91</u>	<u>9,808,187,963.80</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	9,709,957,856.91	9,808,187,963.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,009,407,276.32	2,009,407,276.32
51101	Өмч: - төрийн	2,009,407,276.32	2,009,407,276.32
512	Хуримтлагдсан үр дүн	6,372,003,036.74	6,470,233,143.63
51210	Өмнөх үеийн үр дүн	5,866,481,328.99	6,372,003,036.74
51220	Тайлант үеийн үр дүн	505,521,707.75	98,230,106.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,328,547,543.85	1,328,547,543.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>9,709,957,856.91</u>	<u>9,808,187,963.80</u>

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,588,833,466.00	1,697,660,392.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	800,597,110.00	427,988,050.00
120	Нийтлэг татварын бус орлого	800,597,110.00	427,988,050.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	800,597,110.00	427,618,050.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	370,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	788,236,356.00	1,269,672,342.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,965,365.00	12,022,342.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,965,365.00	12,022,342.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	762,270,991.00	1,257,650,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	762,270,991.00	1,257,650,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,072,003,424.91	1,599,430,285.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,072,003,424.91	1,599,430,285.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,070,900,179.91	1,563,165,003.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	476,787,499.00	844,668,121.85
210101	Үндсэн цалин	361,463,245.00	463,101,406.70
210102	Нэмэгдэл	109,300,254.00	362,389,715.15
210104	Урамшуулал	6,024,000.00	19,177,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,819,500.00	117,452,000.00
210201	Тэтгэврийн даатгал	44,597,200.00	79,867,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,805,600.00	9,396,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,844,500.00	4,698,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	961,100.00	4,698,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,611,100.00	18,792,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,261,837.00	39,290,583.19
210301	Гэрэл, цахилгаан	4,057,360.00	5,203,377.19
210302	Түлш, халаалт	26,204,477.00	34,087,206.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,629,600.00	56,873,300.99
210401	Бичиг хэрэг	3,323,200.00	3,847,100.00
210402	Тээвэр, шатахуун	33,597,300.00	47,368,142.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,385,000.00	5,140,058.99
210404	Ном, хэвлэл	-	38,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	324,100.00	-
2105	Нормативт зардал	957,388.00	648,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	530,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	427,388.00	648,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,452,112.00	4,616,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	527,700.00	105,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	147,700.00	-
210604	Урсгал засвар	10,776,712.00	4,511,800.00
2107	Томилолт, зочны зардал	8,545,540.00	8,760,350.00
210702	Дотоод албан томилолт	5,023,040.00	6,504,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,522,500.00	2,256,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,956,190.00	45,998,920.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,591,490.00	45,115,920.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	77,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	411,000.00	110,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	512,000.00	663,000.00
210807	Газрын төлбөр	131,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	358,490,513.91	444,856,927.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,583,492.00	72,805,219.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	896,288.00	600,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	314,010,733.91	371,451,408.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,103,245.00	36,265,281.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00	35,550,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,750,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	13,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	403,245.00	424,531.82

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	403,245.00	424,531.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	290,750.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	290,750.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	516,830,041.09	98,230,106.89
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,308,333.34	-
225003	Хөрөнгө оруулалтын гарз	11,308,333.34	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,308,333.34)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	505,521,707.75	98,230,106.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	788,236,356.00	1,269,672,342.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	788,236,356.00	1,269,672,342.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,965,365.00	12,022,342.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,965,365.00	12,022,342.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	762,270,991.00	1,257,650,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	762,270,991.00	1,257,650,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	768,145,656.00	1,235,572,342.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	768,145,656.00	1,235,572,342.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	767,042,411.00	1,199,307,060.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,579,100.00	858,066,937.00
210101	Үндсэн цалин	366,254,846.00	476,500,221.00
210102	Нэмэгдэл	109,300,254.00	362,389,716.00
210104	Урамшуулал	6,024,000.00	19,177,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,819,500.00	117,452,000.00
210201	Тэтгэврийн даатгал	44,597,200.00	79,867,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,805,600.00	9,396,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,844,500.00	4,698,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	961,100.00	4,698,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,611,100.00	18,792,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,184,411.00	39,290,583.19
210301	Гэрэл, цахилгаан	4,978,185.00	3,211,737.09
210302	Түлш, халаалт	28,206,226.00	36,078,846.10
2104	Хангамж, бараа материалын зардал	48,843,110.00	56,230,150.99
210401	Бичиг хэрэг	4,576,400.00	3,242,000.00
210402	Тээвэр, шатахуун	38,589,810.00	47,368,092.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,349,900.00	5,140,058.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	-
2105	Нормативт зардал	960,000.00	588,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	530,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	588,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,426,600.00	6,056,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	578,888.00	424,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	-
210604	Урсгал засвар	10,776,712.00	5,632,300.00
2107	Томилолт, зочны зардал	9,023,040.00	10,370,350.00
210702	Дотоод албан томилолт	5,023,040.00	6,504,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,000,000.00	3,866,350.00

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,471,870.00	46,697,370.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,792,370.00	45,506,370.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	184,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	377,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	838,000.00	467,000.00
210807	Газрын төлбөр	131,000.00	128,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,734,780.00	64,555,369.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,318,080.00	63,492,369.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,416,700.00	1,063,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,103,245.00	36,265,281.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00	35,550,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,750,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		13,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	403,245.00	424,531.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	403,245.00	424,531.82
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	290,750.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		290,750.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,090,700.00	34,100,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,090,700.00	34,100,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,090,700.00	34,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,090,700.00	34,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,090,700.00	34,100,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(20,090,700.00)	(34,100,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,009,407,276.32	1,328,547,543.85	5,866,481,328.99		9,204,436,149.16
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,009,407,276.32	1,328,547,543.85	5,866,481,328.99	-	9,204,436,149.16
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

C07	Тайлант үеийн үр дүн			505,521,707.75		505,521,707.75
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,009,407,276.32	1,328,547,543.85	6,372,003,036.74	-	9,709,957,856.91
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,009,407,276.32	1,328,547,543.85	6,372,003,036.74	-	9,709,957,856.91
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,009,407,276.32	1,328,547,543.85	6,372,003,036.74	-	9,709,957,856.91
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			98,230,106.89		98,230,106.89
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,009,407,276.32	1,328,547,543.85	6,470,233,143.63	-	9,808,187,963.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

БӨА-2025/149/НА-СТА-ТШЗ

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн н	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,366,177,600.00	1,257,225,468.18	108,952,131.8	92.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,366,177,600.00	1,257,225,468.18	108,952,131.8	92.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,322,976,600.00	1,221,675,468.18	101,301,131.8	92.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	939,615,500.00	858,066,937.00	81,548,563.0	91.3
210101	Үндсэн цалин	512,373,000.00	476,500,221.00	35,872,779.0	93.0
210102	Нэмэгдэл	408,065,500.00	362,389,716.00	45,675,784.0	88.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт			-	
210104	Урамшуулал	19,177,000.00	19,177,000.00	-	100.0
210105	Гэрээт ажлын хөлс			-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шим	117,452,000.00	117,452,000.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	79,867,300.00	79,867,300.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,396,200.00	9,396,200.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,698,100.00	4,698,100.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,698,100.00	4,698,100.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	18,792,300.00	18,792,300.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,601,200.00	39,290,583.19	5,310,616.8	88.1
210301	Гэрэл, цахилгаан	6,450,000.00	3,211,737.09	3,238,262.9	49.8
210302	Түлш, халаалт	38,151,200.00	36,078,846.10	2,072,353.9	94.6
210303	Цэвэр, бохир ус			-	
210304	Байрны гүрээс			-	
2104	Хангамж, бараа материалын зардал	57,336,000.00	54,032,958.99	3,303,041.0	94.2
210401	Бичиг хэрэг	3,242,000.00	3,242,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	45,170,900.00	45,170,900.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,753,100.00	5,140,058.99	2,613,041.0	66.3
210404	Ном, хэвлэл			-	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устга	700,000.00	480,000.00	220,000.0	68.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,000.00	-	470,000.0	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал			-	
2105	Нормативт зардал	700,000.00	588,000.00	112,000.0	84.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл			-	
210502	Хоол, хүнс			-	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	588,000.00	112,000.0	84.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,956,600.00	9,056,300.00	1,900,300.0	82.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,243,400.00	3,424,000.00	819,400.0	80.7
210602	Тавилга			-	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,200.00	-	143,200.0	-
210604	Урсгал засвар	6,570,000.00	5,632,300.00	937,700.0	85.7
2107	Томилголт, зочны зардал	11,100,000.00	7,118,350.00	3,981,650.0	64.1
210701	Гадаад албан томилголт			-	
210702	Дотоод албан томилголт	7,100,000.00	3,252,000.00	3,848,000.0	45.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,000,000.00	3,866,350.00	133,650.0	96.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төл	79,652,300.00	77,797,370.00	1,854,930.0	97.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлч	77,288,500.00	76,606,370.00	682,130.0	99.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	513,000.00		513,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	184,800.00	184,800.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,000.00	377,700.00	14,300.0	96.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,400.00	33,000.00	87,400.0	27.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	980,800.00	467,000.00	513,800.0	47.6
210807	Газрын төлбөр	128,500.00	128,500.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	44,300.00	-	44,300.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,563,000.00	58,272,969.00	3,290,031.0	94.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,500,000.00	57,209,969.00	3,290,031.0	94.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,063,000.00	1,063,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,201,000.00	35,550,000.00	7,651,000.0	82.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,201,000.00	35,550,000.00	7,651,000.0	82.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэ	21,750,000.00	21,750,000.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,400,000.00	13,800,000.00	6,600,000.0	67.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,051,000.00	-	1,051,000.0	-
13	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,366,177,600.00	1,257,225,468.18	108,952,131.8	92.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,366,177,600.00	1,257,225,468.18	108,952,131.8	92.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,366,177,600.00	1,257,225,468.18	108,952,131.8	92.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	38	(7.0)	
620001	Удирдах ажилтан	14	14	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	-	
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	
620004	Гэрээт ажилтан	5	12	(7.0)	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31	38	(7.0)	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10	-	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	3	3	-	
650010	Гэрээт ажилтан	5	12	(7.0)	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	13	13	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,731,592.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,731,592.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,731,592.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,197,192.00
210402	Тээвэр, шатахуун	2,197,192.00
2107	Томилолт, зочны зардал	3,252,000.00
210702	Дотоод албан томилолт	3,252,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,282,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,282,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,022,342.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,022,342.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,022,342.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын зорилго нь “Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөн буй орчинд уян хатан зохицож чаддаг бөгөөд идэвхтэй, санаачилгатай, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг, эцсийн үр дүн эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино”.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Эдийн засаг, санхүүгийн стратегийн төлөвлөлт бодлогын шийдвэр боловсруулахад дэмжлэг үзүүлэх.
- Салбарын стратегийн төлөвлөлт, бодлогын шийдвэр боловсруулах, хэрэгжилтийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх.
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах.
- Иргэдэд төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй, хөнгөн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүрэг нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болон хэтийн төлөвлөгөөний биелэлтийг хянах, байгууллага, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг тасралтгүй хангаж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахад оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Сумын Засаг даргын тамгын газрын даргын 2019 оны А/02 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 429.5 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,291.6	13,977.6	12,686.0
Урьдчилгаа			
Бараа материал	22,043.0	17,320.5	(4,722.5)
Үндсэн хөрөнгө	9,686,623.3	9,776,889.9	98,230.1
Нийт хөрөнгө	9,709,957.9	9,808,188.0	98,230.1
Өр төлбөр	0		
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,709,957.9	9,808,188.0	98,230.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,709,957.9	9,808,188.0	98,230.1

Дансны авлага 12.7 сая төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 9.7 сая төгрөгөөр, цалингийн урьдчилгаа 3.0 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Бараа материалын данс 4.7 сая төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалын зарцуулалттай холбоотой.

Үндсэн хөрөнгийн данс 98.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.Энэ нь сумын ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжсэн 298.8 сая төгрөгийн барилга байгууламж, бусад хөрөнгө, 3.0 сая төгрөгийн мотоцикл, 11.3 сая төгрөгийн компьютер, принтер, 1.2 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг, Аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжсэн 54.8 сая төгрөгийн барилга байгууламж, бусад хөрөнгө, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 29.3 сая төгрөгийн мотоцикл, 19.5 сая төгрөгийн компьютер, принтер, 8.8 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг орлого авснаар нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардлаар буурсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгээр 98.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 972.8 сая төгрөг, нийт зарлагыг 972.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 217.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,190.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3 удаа төсвийн тодотгол хийгдэж нийт дүнгээр 233.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,336.1 төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,366.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,257.2 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулсан ба сумын орон нутгийн төсвийн орлого тасарснаас 108.5 сая төгрөгийн

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

санхүүжилтийг дутуу олгосон байна. Жилийн эцэст 0.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан орон тоо Тамгын газарт 20, багийн Засаг дарга 11, нийт 31 боловч, гүйцэтгэлээр 38 албан хаагч ажиллаж, орон тооноос 7 орон тоо илүү ажиллуулсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,257.2 сая төгрөг буюу 92.0 хувьтай байгаа нь санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	1,366,177.6	1,257,225.4	108,952.2	92.0%
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	850,833.8	752,504.6	98,329.2	88.4%
80102	Туслах үйл ажиллагааны зардал	365,877.8	363,402.9	2,474.9	99.3%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	43,201.0	35,550.0	7,651.0	82.3%
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	30,000.0	30,000.0	0	100.0%
81701	Байгаль орчныг хамгаалах	76,265.0	75,767.9	497.1	99.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгаануудын дүн дараах байдалтай байна. Үүнд:

- Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу сан байгуулаагүй, ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй байна.
- Худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй, нийт 18.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшлыг худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгдээгүй зөрчилд албан шаардлага өгч ажиллав.
- Бараа үйлчилгээний бусад зардлаас баярын арга хэмжээнд зориулан нийт 11.8 сая төгрөгийг бэлэг дурсгал, шагналд олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хавтгайруулан зарцуулсан зөрчилд албан шаардлага өгч ажиллав.
- Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг 7 орон тоогоор илүү хэтрүүлж, төсвөөс 43,232.6 мянган төгрөг зарцуулсан зөрчилд зөвлөмж өгөв.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргаас 6.0 сая төгрөгийн, Статистикийн хэлтсээс 6.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээр авч аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс нээсэн эрхийн дагуу зарцуулж, жилийн эцэст 0.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 63.5 сая төгрөгийн бараа материал, 34.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 3/19 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар тогтоосон суурь үзүүлэлтээр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 12,060.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж тайлант оны нийт зардлын дүн их хэмжээгээр өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 75 хувиар буюу 17,993.6 мянган төгрөгөөр тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

БӨА-2025/149/НА-СТА-ТШЗ

1. Засаг даргын Тамгын газрын үйлчлэгчээр ажиллаж байгаад өндөр настны тэтгэвэрт гарсан иргэнд өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж олгож, 1.8 сая төгрөгийн, тэтгэмжийг давхардуулан олгосон,
2. Бараа үйлчилгээний бусад зардлаас цагаан сар, наурыз, шинэ жилийн баяр, багуудын өдөрлөгт зориулан нийт 11.8 сая төгрөгийг бэлэг дурсгал, шагналд олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан,
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй, 18.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшлыг цахим дэлгүүрээс бусад газраас худалдан авсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 1,219.5 төгрөгийн 67 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 173.5 төгрөгийн 14 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өмнөх аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж олгосон 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 23.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 26.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөн ба бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	449.1	1	449.1	100%
Албан шаардлага	1	23,000.0	1	23,000.0	100%
Зөвлөмж	1	26,102.7	1	26,102.7	100%
Нийт дүн	3	49,551.8	3	49,551.8	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалингийн зардал, хөрөнгийн тооллогыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **178,385.2** мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад **178,385.2** мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

Санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн дахин үнэлгээний дүнг 70,785.1 мянган төгрөгөөр дутуу, санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгаас авсан санхүүжилтийг 35.0 мянга, жилийн эцэст төвлөрүүлсэн шилжүүлгийг 35.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, үнэ төлбөргүй авсан 370.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дүнгээс хасаж залруулав.

Мөнгөн гүйлгээний тайланд орон нутгаас авсан санхүүжилтийг 35.0 мянга, жилийн эцэст төвлөрүүлсэн шилжүүлгийг 35.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, өмчийн өөрчлөлтийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээний дүнг 70,785.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгаас авах санхүүжилтийн төлөвлөгөөг 36,215.0 мянган төгрөгөөр дутуу, орон нутгаас авсан санхүүжилтийг 460.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн 4.1.3, 5 дугаар зүйл 5.1-ийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Сангийн сайдын 2023 оны А/229 тоот тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" болон УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **132,234.6** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, **2,050.0** мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, **86,952.0** мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, **43,232.6** мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 2,050.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.Үүнд:

1.Засаг даргын Тамгын газрын үйлчлэгчээр ажиллаж байгаад өндөр настны тэтгэвэрт гарсан Т.Ленад өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж олгож, Тамгын газрын даргын 2024 оны №Б/25 тоот тушаалаар 1,800.0 мянган төгрөгийн тэтгэмжийг давхардуулан олгосон,

2. Монголын мэргэшсэн нягтлан бодогчийн институтын Баян-Өлгий салбарт 250.0 мянган төгрөгийг сургалтын төлбөрт нотлох баримтгүй шилжүүлж төсвийн хөрөнгийг зүй бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 4.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомж зөрчин олгосон 2,050.0 мянган төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар 96,952.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

1.Бараа материалын дансанд мал амьтад дансанд 9,900.0 мянган төгрөгийн үнэтэй 62 толгой бог мал бүртгэлтэй байгаа боловч бодитоор байхгүй байгааг санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-ийн 2, Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

2.Тээвэр шатахуун болон бараа үйлчилгээний бусад зардлаас 47,170,0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан боловч албаны машин эвдэрсэн гэх шалтгаанаар жолоочийн замын тооцооны хуудас хөтлөөгүй, шатахуун хэрэглэсэн эрх бүхий албан тушаалтнуудаар жагсаалт үйлдэж гарын үсэг зуруулаагүй, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, - 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.3, Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
БӨА-2025/149/НА-СТА-ТШЗ

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Бараа үйлчилгээний бусад зардлаас янз бүрийн баярын арга хэмжээнд зориулан 11,782.0 мянган төгрөгийг бэлэг дурсгал, шагналд олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хавтгайруулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-ийн 15.1.3, 15.1.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант онд худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй, 18,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшлыг худалдан авахдаа цахим худалдан авалтын журмыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 37 дугаар зүйлийн 37.1.2, 38 дугаар зүйлийн 38.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бүтэц, орон тоотой холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Улаанхус сумын ИТХ-ын 2024 оны “2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 07 дугаар тогтоол, сумын Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны “Бүтэц, орон тоо батлах тухай” А/01 тоот тушаалаар Тамгын газрын ажиллагсдын орон тоог 20, багийн Засаг дарга нарын орон тоог 11, нийт 31 орон тоогоор баталсан боловч, гүйцэтгэлээр 38 албан хаагч ажиллаж, батлагдсан орон тооноос 7 орон тоогоор илүү ажиллаж төсвөөс 43,232.6 мянган төгрөг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.9-т “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох”, 66 дугаар зүйлийн 66.1-т “Сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 66.1.7-т “тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн БӨА-2025/149/НА-СТА-ТШЗ

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 5.1.2-т “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох” гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

1.1 Өгсөн зөвлөмж: Батлагдсан орон тооны хязгаарт багтаан орон тоог үндэслэлтэй тогтоох, орон тооны нягтралыг сайжруулах замаар төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СБТ-д хөрөнгийн дахин үнэлгээний дүнг дутуу тайлагнасан	1	70,785.1			1	70,785.1	1	70,785.1				
СҮДТ-д нутгаас авсан санхүүжилтийг 35.0 мян, жилийн эцэст төвлөрүүлсэн шилжүүлгийг 35.0 мян. төгрөгөөр илүү, үнэ төлбөргүй авсан 370.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дүнгээс хасаж залруулсан	1	440.0			1	440.0	1	440.0				
МГТ-д орон нутгаас авсан санхүүжилтийг 35.0 мянга, жилийн эцэст төвлөрүүлсэн шилжүүлгийг 35.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	70.0			1	70.0	1	70.0				
ӨӨТ-д хөрөнгийн дахин үнэлгээний дүнг дутуу тайлагнасан	1	70,785.1			1	70,785.1	1	70,785.1				

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ТГТ орон нутгаас авах санхүүжилтийн төлөвлөгөөг 36,215.0 мян. төгрөгөөр дутуу, орон нутгаас авсан санхүүжилтийг 460.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	36,675.0		1	36,675.0	1	36,675.0				
Дүн	5	178,755.2		5	178,755.2	5	178,755.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэг удаагийн тэтгэмжийг давхар олгосон	1	2,050.0	1	2,050.0								
Бодитоор байхгүй малыг санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнасан	1	9,900.0			1	9,900.0						
Шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй	1	47,170.0			1	47,170.0						
Илүү орон тоогоор ажилласан	1	43,232.6					1	43,232.6				
Дүн	4	102,352.6	1	2,050.0	2	57,070.0	1	43,232.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								

Улаанхус сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ТХТХ-ийг зөрчиж бэлэг дурсгал, шагналд хавтгайруулан зарцуулсан	1	11,782.0			1	11,782.0		
Цахим худалдан авалтыг хууль зөрчсөн	1	18,100.0			1	18,100.0		
Дүн	2	29,882.0			2	29,882.0		
Нийт дүн	2	29,882.0			2	29,882.0		